

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар  
сарын 25-ны өдрийн А/261 дүгээр  
тушаалын гуравдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР  
ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ  
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**2023 он**

**[ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН 27 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ]**

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР  
ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ  
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
БАРИМТ БИЧИГ**

Тендер  
шалгаруулалт  
ын нэр:

*[Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал]*

Тендер  
шалгаруулалт  
ын дугаар:

*[ДААДСЦ/27/20240202010]*

## САНАМЖ

Тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл болох тул тендер шалгаруулалт зохион байгуулах, түүнд оролцохын өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган батлагдсан журам, заавар, дүрэм, гэрээний нөхцөл, тендер шалгаруулалтын жишиг баримт бичигтэй сайтар танилцахыг зөвлөж байна.

Захиалагч нь тендер шалгаруулалт зохион байгуулахад худалдан авах ажиллагааны үндсэн зарчмууд болох өрсөлдөх боломжтой, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтална.

Энэхүү харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын баримт бичиг нь тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолтын шаардлага, тендерийн жишиг маягт, гэрээний нөхцөл гэсэн бүлэгтэй.

Тендер шалгаруулалтын зааварчилгаа бүлгийн зүйл, заалтыг нэмж, эсхүл өөрчилж үл болно. Захиалагч өгөгдлийн хүснэгтийг зааварчилгаатай уялдуулан боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

Техникийн тодорхойлолт бүлэгт захиалагчийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгасан байна.

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор налуугаар бичсэн тохирох мэдээллийг зааварт нийцүүлэн бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ. Гэрээний нөхцөл бүлэг нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулагдах гэрээний зүйл, заалтуудыг агуулсан байна.

Харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын анхаарах асуудлууд:

- ❖ Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээ /Ажил цахим каталогт бүртгэгдсэн байна./
- ❖ Тендер шалгаруулалтын зарлал нийтэлж, бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид урилга хүргүүлж, үнийн санал дуудна. Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим систем /[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)/-д нийтэлнэ.
- ❖ Үнийн саналыг дуудах хугацаа нь урилга хүргүүлсэн, зарлал нийтэлсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрийн дараа байхаар тогтоосон байна.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдэд цахим системээс ялгах дугаар олгоно.
- ❖ Заасан хугацаанд сонирхогч этгээд тендерийг цахим системд ирүүлнэ.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагааг 2 хүртэл цагийн хугацаагаар зохион байгуулна. Уг хугацааны дотор саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар **эхэнд эрэмбэлэгдсэн** үнийн санал бүхий оролцогчийг тодорхойлно.
- ❖ **Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.**

Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол **удаах эрэмбэлэгдсэн** тендерийг хянан үзнэ.

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА .....	5
II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ .....	11
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	13
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	13
V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ .....	28
VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ .....	1

# I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

## А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.Тендерийн цар хүрээ** 1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) авах тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.
- 2.Санхүүжилтийн үүсвэр** эх 2.1.Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
- 3.Худалдан ажиллагааны тогтоомж** авах хууль 3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 3.2.Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
- 3.3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.
- 4.Оролцогчид тавигдах ерөнхий шаардлага** 4.1.Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.
- 4.2.Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр ерөнхий шаардлага хангасан байна.
- 4.3..Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.
- 4.4.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 4.5.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 5.Туслан гүйцэтгэгч** 5.1.Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгүүлэх мэдээллийг гэрээнд заасан байна.
- 5.2.Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 5.3.Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 6.Худалдан ажиллагааны систем** авах цахим 6.1.Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын

дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

#### **Б.АГУУЛГА**

- 7.Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл**
- 7.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.  
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;  
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;  
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;  
IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;  
V Бүлэг. Гэрээний нөхцөл
- 7.2.Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй.
- 7.3.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 8.Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах**
- 8.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.
- 8.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.
- 8.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.
- 8.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно.
- 8.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 9-д заасныг мөрдөнө.
- 9.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**
- 9.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 9.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.
- 9.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
- 10.Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 10.1.Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.
- 10.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.
- 10.3.Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.
- В.Тендер бэлтгэх**
- 11.Тендер шалгаруулалтын хэл**
- 11.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл

хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

11.2.3.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

11.3.Хэрэв ТШЗ-ны 11.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

11.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

## **12.Тендерийн бүрдэл**

12.1.Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

12.1.1.ТШЗ-ны 13-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

12.1.2.Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

12.1.3.өгөгдлийн хүснэгтэд заасан бол ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

12.1.4.ТШЗ-ны 15-д зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

12.1.5.ТШЗ-ны 16, 17, 18-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

12.1.6.ТШЗ-ны 19-д заасны дагуу ажлыг техникийн тодорхойлолтын шаардлагад гүйцэтгэхийг нотлох баримт бичиг;

12.1.7.ТШЗ-ны 22.4-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

12.2.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

## **13.Тендерийн маягт жишиг**

13.1.IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

## **14.Хувилбарт санал**

14.1.өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт илгээж болно.

## **15.Ерөнхий шаардлага**

15.1.IV бүлгийн Маягт 1-ийн дагуу бэлтгэсэн хуулийн 7.2-т заасан мэдэгдэл ирүүлнэ.

15.2.Хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой ирүүлэх баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заана.

15.3.Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх ба нотлох баримт бичиг ирүүлнэ.

- 16. Чадавхын болон туршлагын шаардлага** 16.1. ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.  
16.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.  
16.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн тус бүр болон хамтдаа чадавхын болон туршлагын шаардлагыг өгөгдлийн хүснэгтэд хүснэгтэд заасан хувь, хэмжээгээр хангасан байна.
- 17. Санхүүгийн чадавхын шаардлага** 17.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.  
17.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.  
17.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн тус бүр болон хамтдаа хангавал зохих шаардлагыг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18. Техникийн болон туршлагын шаардлага** 18.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.  
18.2. Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.  
18.3. Үйлчилгээ үзүүлэхэд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19. Үйлчилгээг техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэхийг нотлох баримт** 19.1. Оролцогч үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон эцсийн үнээр захиалагчийн баталсан ажлын даалгаврын дагуу үйлчилгээ үзүүлэх тухай мэдэгдлийг IV бүлгийн маягт 1-ийн дагуу баталгаажуулж ирүүлнэ.
- 20. Тендерийн үнэ** 20.1. Үнийн санал ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.  
20.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.  
20.3. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21. Тендерийн валют** 21.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
- 22. Тендерийн үнэ** 22.1. Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.  
22.2. Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга



хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

22.3.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

22.4.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

### **23.Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

23.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.3.Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.

#### **Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ**

### **24.Тендер баталгаажуулах, илгээх**

24.1.Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.

24.2.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягыг ТШЗ-ны 24.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

24.3.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

24.4.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 24.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

### **25.Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

25.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

#### **Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА**

### **26.Үнийн санал дуудах хугацаа**

26.1.Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 25.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дараа эхэлнэ.

26.2.Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана.

- 26.3.ТШЗ-ны 26.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.
- 27.Тендер нээх** 27.1.ТШЗ-ны 26.3-т заасан хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.

#### **Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

- 28.Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх** 28.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 12-т тендерийн бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.
- 28.2.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.
- 29.Тендерийн талаар тодруулга авах** 29.1.Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.

#### **Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 30.Мэдэгдэл хүргүүлэх** 30.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 31.Гүйцэтгэлийн баталгаа** 31.1.Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 31.2.Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 32.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 32.1.Захиалагч ТШЗ-ны 7.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 32.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 32.3.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 32.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ.
- 32.4.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

#### **Ж.БУСАД**

- 33.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах** 33.1.Захиалагч ТШЗ-ны 28.2-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг ТШЗ 30.1-д заасан шийдвэрт заана.
- 33.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.
- 34.Тендер шалгаруулалтад гомдол гаргах** 34.1.Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу хянан шийдвэрлэнэ.

## II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагчийн нэр: <b>[Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэг]</b>
<b>ТШЗ 1.1</b>	Зарлалын дугаар: <b>[цахим системд нийтэлсэн урилгын дугаарыг бичнэ.]</b> Тендер шалгаруулалтын нэр: <b>[ багцтай 6-н багцаас бүрдэнэ.]</b>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр: <b>[ урсгал зардал]</b>  Нийт төсөвт өртөг: <b>[62,875,000]</b> <b>[Багц №1: үхрийн мах, махан бүтээгдэхүүн-26,496,000</b> <b>Багц №2: Гурилан бүтээгдэхүүн-10,780,000</b> <b>Багц №3: Төмс, хүнсний ногоо-7,777,000</b> <b>Багц №4: Гурил-2,400,000</b> <b>Багц №5: Хуурай хүнс, жимс жимс жимсгэнэ-9,122,500</b> <b>Багц №6: Сүү, сүүн бүтээгдэхүүн-6,299,500]</b>
<b>Б.АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 8.1</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хариуцсан ажилтан: [Үнэлгээний хорооны нарийн бичиг 99376150 Хаяг: <b>[Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэг.]</b> Утасны дугаар: <b>[70376227.]</b> Цахим шуудан: <b>[tsetserleg27@esrp.edu.mn]</b>
<b>ТШЗ 10.1</b>	Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: <b>[ “ҮГҮЙ” нэгийг сонгоно. Хэрэв тийм бол уулзал болох газар, огноо, цагийг бичнэ.]</b>
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 11.2</b>	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл. <b>[ТШЗ 11.2-т заасны дагуу тохирох хэлийг сонгож бичнэ.]</b>
<b>ТШЗ 14.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“ЗӨВШӨӨРӨХГҮЙ”</b>
<b>ТШЗ 17.1</b>	Санхүүгийн чадавхын шаардлага: Шаардана. Сүүлийн нэг жил <b>[Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн нөхцөл байдлын талаарх зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг заана.]</b>
<b>ТШЗ 17.2</b>	Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: <b>[оролцогчийн сүүлийн нэг жилийн санхүүгийн үйл ажиллагааны бичиг баримт]</b>
<b>ТШЗ 18.1</b>	Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>[“Шаардана” ]Сүүлийн нэг жилийн ажлын туршлага</b>  Ажил гүйцэтгэх хүний нөөц: <b>[“Шаардана” ]Сүүлийн нэг жилийн ажлын туршлага</b>  Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <b>[ “Шаардахгүй”</b> Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: <b>[“Шаардана” Жишээ: батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [30] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг ТШЗ 17.2-т заасан хугацаанд доод тал нь [1] удаа байх. Захиалагч ижил төстэй үйлчилгээг тухайлан зааж болно.]</b>  Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: <b>[ “Шаардахгүй”.]</b>

	Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: <b>[“Шаардана”]</b>
<b>ТШЗ 18.2</b>	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: Сүүлийн нэг жилийн ажлын туршлага  <b>[ТШЗ 17.1-д заасан шаардлагатай уялдуулан хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож заана.]</b>
<b>ТШЗ 18.3</b>	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>[“Шаардана”]</b>
<b>ТШЗ 20.2</b>	Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>[“ТОХИРУУЛАХГҮЙ”]</b>
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>ТШЗ 24.4</b>	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <b>[ТШЗ 24.3-т зааснаас бусад ил болгох баримт бичгүүдийг жагсаан бичнэ.]</b>
<b>ТШЗ 25.1</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Огноо: <b>[2024,02,27]</b> Цаг: <b>[11:30]</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### САНАМЖ

Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөв), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендер оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.
- Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгох бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### АЖЛЫН ДААЛГАВАР

[ажлын даалгаврыг хавсаргана уу.]

## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр: **Бусад хүнсний бүтээгдэхүүн**

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар
1	Варень	Варень нь MNS 6308:2012 стандартын дагуу нэрсний чанамал гүзээлзгэний чанамал, аньсны чанамал, үхрийн нүдний чанамал, бичил биетний ерөнхий тоо 1 гр-д/ MNS ISO 4833:1995 6*10, 9*10, 2*10, 4*10, MNS ISO 6579:1999 salmonello spp /25 гр-д/ илрээгүй, MNS iso 7937:2000 илрээгүй.	Монгол улсад үйлдвэрлэсэн бол итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан байна.
2	Гоймон, шпагетти	Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн шпагетти төрөл бүрийн хэлбэртэй.	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан байна.
3	Нарийн гоймон	Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн / MNS 142-85 хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторын ундны ус хүнсний хими хор судлал хөгц мөөгөнцөр хүнд металлын лабораторын 15340-15346 тоот шинжилгээний дүнгийн тэмдэглэлтэй. Ундны ус, хүнсний химийн лабораторын шинжилгээгээр үзүүлэлтэнд нь хөгц мөөгөнцөрийн шинжилгээгээр 1г-д хөгц мөөгөнцөр, хор судлалын шинжилгээгээр афлатоксийн В1, В2 тус тус илрээгүй. Хүнд металлын үлдэгдэл тодорхойлох шинжилгээгээр хар тугалга 0,04-0,17 мг/кг кадьюми 0,001мг/кг зэс 2,51-2,89 мг/кг байна. Чийглэг 5,67% эзлэхүүний өсөлт 1,1 больц минут мэдрэхүй шаргал өнгөтэй хөндий гоймон.	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
		Гурвалжин будаа нь MNS 4293-95 гадаад хэлбэр дүрс цэцгийн хайрснаас	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн

4	Гурвалжин будаа	салгаж цэвэрлэсэн гурвалжин будааны гурван талт самранцар үртэй байна энэ нь шаардлагад нийцсэн .Өнгө шаравтар болон бор туяатай цайвар өнгөтэй үнэр амт гурвалжин будааны өвөрмөц үнэр ,амттай эвгүй, хөгц зэрэг гашуун амт үнэргүй байна. Бүтэн цөм 99,8% -иас ихгүй Бяцалсан цөм 0,2% тай чийглэг 5,01%тай хэмхдэс 0,2% Хөнөөлт шавьж хачиг тэдгээрийн өндөг авгалдайгүй байна.	хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
5	Цагаан будаа	Цагаан будаа нь MNS ISO 7301-2000 стандартад нийцсэн өнгөлсөн цагаан будаа СА3 5-5-13 стандартад нийцсэн чийг 15%-иас ихгүй 10,85% цайвар шаргал өнгөтэй,хэвийн үнэртэй, гадны амт үнэргүй, урт болон зуйван дугуй хэлбэртэй будааны хольцтой, Больц 0,5% -иас ихгүй хэвийн гадны амт үнэргүй, органик ба органик бус хольц илрээгүй, бүтэн будаа 92% эвдэрсэн будаа 8% үрийн эмтэрхий 0,1%-иас ихгүй 0,7% гэмтсэн үр 3,0%-иас ихгүй 1,6% гуриланцар үр 11,0%-иас ихгүй 0,8%, MNS 2782-01-14% MNS 2782-02-14 хорио цээртэй хөнөөлт шавьж, хачиг тэдгээрийн өндөг, авгалдай, хүүхэлдэй илрээгүй MNS 5132-0 стандартыг хангасан хөгц мөөгөнцөр 1г–д илрүүлэхэд 1г-д хөгц мөөгөнцөр илрээгүй. Масс детектортой хийх хроматографийн арга ЭАХХСЛ 5,4,19 стандартад Supermethrin мг/кг deltamethrin мг-кг шинжлэхэд илрээгүй. MNS 4499-97 кадми мг/кг 0.001, MNS 4496-97 хар тугалга	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
6	Шар будаа	Шар будаа нь MNS ISO 4833-95 стандартад нийцсэн өнгөлсөн цагаан будаа СА3 5-5-13 стандартад нийцсэн чийг 15%-иас ихгүй 10,85% цайвар шаргал өнгөтэй, хэвийн үнэртэй, гадны амт үнэргүй, урт болон зуйван дугуй хэлбэртэй будааны хольцтой, Больц 0,5% -иас ихгүй хэвийн гадны амт үнэргүй, органик ба органик бус хольц илрээгүй, бүтэн будаа 92% эвдэрсэн будаа 8% үрийн эмтэрхий 0,1%-иас ихгүй 0,7% гэмтсэн үр 3,0%-иас ихгүй	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан

		1,6% гуриланцар үр 11,0%-иас ихгүй 0,8%, MNS 2782-01-14% MNS 2782-02-14 хорио цээртэй хөнөөлт шавьж, хачиг тэдгээрийн өндөг, авгалдай, хүүхэлдэй илрээгүй	
7	Хүүхдийн будаа	Хүүхдийн будаа нь MNS 6308:2012 стандартын дагуу хүнд металлын үлдэгдэл тодорхойлох шинжилгээгээр кадми 0,001 мг/кг хар тугалга 0,001 мг нян судлалын шинжилгээгээр 0,1 гр мл-д колиформ 25 гр-/мл-д салмонелл хор судлалын шинжилгээгээр афлатоксин В1,В2 тус тус илрээгүй, цацрагийн хяналтын лабораторийн шинжилгээгээр цацрагийн бохирдолгүй хүнсний химийн лабораторийн шинжилгээгээр шар өнгөтэй, нэгэн жигд нарийн ширхэгтэй хуурай нунтаг гадны механик хольцгүй исгэлэн 13,0 т чийглэг 1,73 %	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
8	Хөц будаа	Хөц будаа нь: MNS ISO 5272-2003 стандартад нийцсэн өнгөлсөн цагаан будаа СА3 5-5-13 стандартад нийцсэн чийг 15%-иас ихгүй 10,85% цайвар шаргал өнгөтэй, хэвийн үнэртэй, гадны амт үнэргүй, урт болон зуйван дугуй хэлбэртэй будааны хольцтой, Больц 0,5% -иас ихгүй хэвийн гадны амт үнэргүй, органик ба органик бус хольц илрээгүй, бүтэн будаа 92% эвдэрсэн будаа 8% үрийн эмтэрхий 0,1%-иас ихгүй 0,7% гэмтсэн үр 3,0%-иас ихгүй 1,6% гуриланцар үр 11,0%-иас ихгүй 0,8%, MNS 2782-01-14% MNS 2782-02-14 хорио цээртэй хөнөөлт шавьж, хачиг тэдгээрийн өндөг, авгалдай, хүүхэлдэй илрээгүй	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
9	Давс, бор давс	Давс нь Эх оронд үйлдвэрлэгдсэн, сайн чанарын, иоджуулсан, цавдан нуурын давстай дүйцэхүйц Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн. MNS ISO 7932:1999 стандартад нийцсэн бацилус цереус илрээгүй, MNS ISO 6579:1999 салмонелл илрээгүй, MNS ISO 7251:1995 гэдэсний савханцар илрээгүй, MNS 5132:2002	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан



		хөгз мөөгөнцөр илрээгүй, MNS 4496:1997 хар тугалга мг/кг ихгүй 0,29 байна, MNS 4499:1997 кадми мг/кг ихгүй 0,06 /	
10	Исгэгч	Исгэгч: MNS ISO 7932:1999 стандартад нийцсэн бацилус цереус илрээгүй, MNS ISO 6579:1999 салмонелл илрээгүй, MNS ISO 7251:1995 гэдэсний савханцар илрээгүй, MNS 5132:2002 хөгз мөөгөнцөр илрээгүй, MNS 4496:1997 хар тугалга мг/кг ихгүй 0,29 байна, MNS 4499:1997 кадми мг/кг ихгүй 0,	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
11	Овьёос	Овьёос нь MNS 4293-95 гадаад хэлбэр дүрс цэцгийн хайрснаас салгаж цэвэрлэсэн гурвалжин будааны гурван талт самранцар үртэй байна энэ нь шаардлагд нийцсэн. Өнгө шаравтар болон бор туяатай цайвар өнгөтэй үнэх амт гурвалжин будааны өвөрмөц үнэр ,амттай эвгүй,хөгц зэрэг гашуун амт үнэргүй байна.Бүтэн цөм 99,8% -иас ихгүй Бяцалсан цөм 0,2% тай .Чийглэг 5,01%тай хэмхдэс 0,2% Хөнөөлт шавьж хачиг тэдгээрийн өндөг авгалдай	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
12	Горох /вандуй/	Горох, вандуй нь:MNS ISO 5272-2003 стандартад нийцсэн өнгөлсөн СА3 5-5-13 стандартад нийцсэн чийг 15%-иас ихгүй 10,85% цайвар шаргал өнгөтэй,хэвийн үнэртэй, гадны амт үнэргүй, урт болон зуйван дугуй хэлбэртэй будааны хольцтой, Больц 0,5% -иас ихгүй хэвийн гадны амт үнэргүй, органик ба органик бус хольц илрээгүй, бүтэн будаа 92% эвдэрсэн будаа 8% үрийн эмтэрхий 0,1%-иас ихгүй 0,7% гэмтсэн үр 3,0%-иас ихгүй 1,6% гуриланцар үр 11,0%-иас ихгүй 0,8%, MNS 2782-01-14% MNS 2782-02-14 хорио цээртэй хөнөөлт шавьж, хачиг тэдгээрийн өндөг,авгалдай ,хүүхэлдэй илрээгүй	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан Гарал үүслийн гэрчилгээтэй байна.
13	Хүнсний сод	Хүнсний сод: Хүнсний зориулалттай, эрүүл ахуйн шаардлага хангасан	

14	Ургамлын тос	Ургамлын тос нь MNS 4551-1998 стандартаар ГБЭТ 25г ургалтгүй MNS ISO 5132:02 хөц мөөгөнцөр 1.0 ургалтгүй .MNS ISO 0525: 1994 стандартаар гадны үнэргүй, нэр төрөлдөө тохирсон өнгөтэй нягт, г/см куб 0,92,хугарлын илтгэгч нь 190,4 болно.	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
15	Хуурай цай	Дугуй булант, болон хадагтай цайны төрөл сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн.	
16	Далайн байцаа /шөлний/, Гүнждийн үртэй далайн байцаа	Солонгос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц, Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
17	Элсэн чихэр, бор элсэн чихэр	Элсэн чихэр нь MNS 4496:1997 сорилтын аргын тэмдэглэгээ хар тугалга мг/кг 1 дүгээрт 0,002 2 дугаарт 0,002 MNS 4499:1997 1 дүгээрт 0,0003 2 дугаарт 0,0003 тус тус зөвшөөрөгдсөн. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори эрүүл ахуйн хор судлалын хяналтын лаборатори ургамлын эрүүл ахуй хорио цээрийн итгэмжлэгдсэн лаборатори УЭА 1773 тоот цацрагын хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн х/0221 тоот шинжилгээ.Ургамлын эрүүл ахуй хорио цээрийн шинжилгээгээр элсэн чихэр нь цэвэршүүлэн ба талстжулсан сахарын хольцгүй чийглэг 0,02% үнслэг 0,07% сахароз 99,74 хорио цээртэй хөнөөлт шавьж хатиг,тэдгээрийн өндөг авгалдай илрээгүй,эрүүл ахуйн нян судлалын шинжилгээгээр колиформ SALIMONEL1 гр-д хөгц мөөгөнцөр тус тус илрээгүй хүнд металлын үлдэгдэл тодорхойлох шинжилгээгээр кадми 0,001 мг/кг хар тугалга 0,054 зөвшөөрөгдөх хэмжээ байна.	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан

18	Төрөл бүрийн будааны няцалбарууд	ОХУ-д үйлдвэрлэсэн, 316-337 ккал-ийн илчлэгтэй, хугацаа хэтрээгүй, сайн чанарын төрөл бүрийн будааны няцалбарууд	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан
19	Үзэм, чангаанз	Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн. /MNS 2782:1:2014 гадаад хорио цээртэй хортон шавьж, MNS 2782:2:2014 хачиг 2292-2301 /	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан
20	Цайны печень	Сайн чанарын, дотоодын үйлдвэрийн болон ОХУ-д үйлдвэрлэсэн эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан байна.
21	Гурил	<p>1. Үр тарианы гурил нь эх орны болон орон нутгийн үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. Нийлүүлэх гурил нь дээд буюу БГ-055, 1-р зэрэг буюу БГ -085 стандартын шаардлага хангасан байх. Гурил нь 15,5%-аас ихгүй чийглэгтэй, 22-оос багагүй цавуулагтай. Гадны үнэр, амтгүй, хортон шавьж, өндөг, авгалдай илрэх ёсгүй. Гурилын шуудай MNS 2515 :1994 стандартын шаардлага хангасан шуудай уутанд савласан байна. Хаяг, шошгын стандартын шаардлага хангасан байна.</p> <p>MNS0244; 2009 нийцсэн физик химийн үзүүлэлтээр чийг 12,4%, үнслэг 0,81%, хүчиллэг 3 град ширхэг үлдэгдэл 3,2% нойтон цавуулаг 27,4% төмөрлөг хольц 00, мэдрэхүйн үзүүлэлтээр буудайн гурилын хэвийн амт үнэртэй исгэлэн буюу хөгцний зэрэг гадны үнэргүй нэр төрөлдөө тохирсон өнгөтэй зажлахад хатуу буюу элсэрхэг зүйл зажлагдахгүй. физик химийн үзүүлэлтээр: чийг -12,4% , үнслэг- 0,53% хүчиллэг-2,9% град ширхэг үлдэгдэл -2,0% нойтон цавуулаг 23,6%, төмөрлөг хольц 00. Ургамал хамгаалал хорио цээрийн лабораторийн дүнгээр хөнөөлт шавьж</p>	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан Гарал үүслийн гэрчилгээтэй байна.

		ургамлын өвчин илрээгүй бактерлогийн лабораторийн шинжилгээний дүнгээр төмсний савханцар ГБЭТ ургалтгүй байна. Хивэг нь лабораторын 31-р сорилтын дүнгээр өөрийн өвөрмөц амт үнэртэй чийг 11%, үнслэг 5,3%, төмөрлөг хольц пестицидийн үлдэгдэл илрээгүй байна /	
--	--	--	--

Барааны нэр: **Талх нарийн боов**

<b>№</b>	<b>Захиалагчийн техникийн тодорхойлолт</b>	<b>Санал болгож буй техникийн тодорхойлолт</b>	<b>Тайлбар</b>
1	-Нарийн боов -Талх	1.Бүтээгдэхүүний чанар, хэлбэр, өнгө гадаргуу, амт үнэр зэрэг стандартын шаардлага хангасан үйлдвэрт баталгаажсан жор технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэсэн  2.Зориулалтын тээврийн хэрэгсэлээр тээвэрлэх	Итгэмжлэгдсэн лабораториар шинжлүүлсэн, эрүүл ахуйн бичигтэй, бүтээгдэхүүний орц найрлага, бусад бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, шинжилгээний бичигтэй байх.

Барааны нэр: **Мах, махан бүтээгдэхүүн- Үхрийн мах, үхрийн элэг, үхрийн гүзээ, үхрийн зүрх**

<b>№</b>	<b>Захиалагчийн техникийн тодорхойлолт</b> <i>(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)</i>	<b>Санал болгож буй техникийн тодорхойлолт</b> <i>(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)</i>	<b>Тайлбар</b> <i>(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)</i>
1	- Үхрийн мах, - Үхрийн элэг, - Үхрийн гүзээ, - Үхрийн зүрх	1.Эрүүл ахуй, ариун цэврийн стандартад нийцсэн, гарал үүслийн гэрчилгээ бүхий 1 дүгээр зэргийн, өнгө, үнэр, биет байдал, гадаргуу, хэлбэр алдагдаагүй мах байна.  2.Махыг хэсэглэж ангилсан байдлаар нийлүүлэх тохиолдолд MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартуудын шаардлагыг хангасан байна.  3.Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүл мал, амьтнаас бэлтгэсэн байна.  4.Мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ,	Эдгээр бараануудын гарал үүслийн бичиг, шинжилгээний бичгийг дагалдуулна.

		<p>итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичигтэй байна.</p> <p>5.Загсаасан буюу сэрвээсэн эсвэл хөргөсөн, хөлдөөсөн мах байна.</p> <p>6.Гулууз болон өрөөл мах нь хэвлийн цагаан шугамын дагуу тэгш ярагдсан, улаан хоолой, мөгөөрсөн хоолойг бүрэн салгасан, дотор өөхний үлдэгдэлгүй, нөжирч хурсан цус, сэвс, үс, шороо зэрэг гадны бохирдолгүй, гадаргуу нь урагдаж гэмтээгүй байна.</p> <p>7.Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ.</p> <p>8.Тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирлогдоогүй, шороо, чийгнээс хамгаалсан бүрхүүлтэй байх ба тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн байна.</p> <p>9.Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө.</p> <p>10.Бүтээгдэхүүнийг ажлын 14 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>	
--	--	---	--

Барааны нэр: **“Сүү, сүүн бүтээгдэхүүн”**

<i>№</i>	<i>Захиалагчийн техникийн тодорхойлолт</i>	<i>Санал болгож буй техникийн тодорхойлолт</i>	<i>Тайлбар</i>
1	-Аарц -Сүү -Ааруул	1.Сүү, сүүн бүтээгдэхүүн нь хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS CAS 1:2003 стандартын шаардлага хангасан эрүүл	Эдгээр бараануудын гарал үүслийн бичиг, шинжилгээний

	<p>-Тараг -Зөөхий</p>	<p>ахуйн тохиромжтой нөхцөлд бэлтгэсэн байна.</p> <p>2. Сүү нь түүхий сүүний техникийн шаардлага MNS 4228:2003 стандартыг хангасан байна.</p> <p>3.Түүхий сүү нь малаас хүнд халдварлах өвчин болон малын гоц халдварт өвчнөөр өвчлөөгүй, вакцин хийлгэсэн, эрүүл бүсээс бэлтгэсэн байна.</p> <p>4.Сүү, сүүн бүтээгдэхүүн нь итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан, мал эмнэлэг, гарал үүслийн гэрчилгээтэй байна.</p> <p>5.Хүнсний нэмэлт будаг, үнэр, амт оруулагч бодис, хувиргасан амьд организмаас гаргасан бүрдлүүдийг агуулаагүй байна.</p> <p>7. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний зориулалтын саванд /бидон/, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>8.Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө.</p> <p>9.Тээврийн хэрэгсэл нь гадны үнэргүй, хортон шавьжаар бохирлогдоогүй, тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн байна.</p> <p>10. Бүтээгдэхүүний хэрэглэх заавар, зөвлөмж зэрэг нэмэлт мэдээллийг дагалдуулж болно.</p> <p>11.Сүү, сүүн бүтээгдэхүүн нь хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS CAC 1:2003 стандартын шаардлага хангасан эрүүл ахуйн тохиромжтой нөхцөлд бэлтгэсэн байна.</p> <p>12.Нийлүүлэгдэх тараг нь эсэг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 , аарц, эзгий, ааруул нь уураглаг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 стандартууд болон эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.</p>	<p>бичгийг дагалдуулна.</p>
--	---------------------------	--	-----------------------------

		<p>13. Үйлдвэрийн болон уламжлалт аргаар бэлтгэсэн, нэгэн жигд бие бүтэцтэй, тослог зохих түвшинд байна.</p> <p>14. Цагаан өнгөтэй, шинэлэг байдлаа хадгалсан, нэгэн жигд бие бүтэцтэй, тослог зохих түвшинд байна.</p> <p>15. Бүтээгдэхүүн хэрэглэх заавар, зөвлөмж зэрэг нэмэлт мэдээллийг дагалдуулж болно.</p> <p>16. Бүтээгдэхүүнийг ажлын 2-5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p> <p>17 Эрүүл, ахуй, ариун цэврийн стандарт шаардлага хангасан, экологийн, монгол уламжлалт аргаар боловсруулсан.</p>	
--	--	---	--

Барааны нэр: **Хүнсний ногоо, жимс жимсгэнэ**

<i>№</i>	<i>Захиалагчийн техникийн тодорхойлолт</i>	<i>Санал болгож буй техникийн тодорхойлолт</i>	<i>Тайлбар</i>
1	-Аньс -Нэрс -Чацаргана	<p>1.Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн, технологийн шаардлага хангасан гадаад байдал амт ба үнэр боловсролт зэргийг баримталсан байна, Байгалийн цэвэр жимс жимсгэнэ, витаминлаг чанартай</p> <p>2. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>	Итгэмжлэгдсэн лабораториар шинжлүүлсэн, эрүүл ахуйн бичигтэй, бүтээгдэхүүний орц найрлага, бусад бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, шинжилгээний бичигтэй байх.
2	Байцаа	<p>1.Нийлүүлэх байцаа нь орон нутагт тариалагдсан, MNS0255:2007 стандартын шаардлага хангасан монгол байцаа байх</p> <p>2.Нитрат, пестицид, цацраг идэвхт бодис, хүнд металлын үлдэгдэл зөвшөөрөгдөх хэмжээнд байна.</p> <p>3.Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлнэ.</p> <p>4.Байцаа нь нягтрал сайтай, бүтэн, цэвэр, өвчлөөгүй, хортон, хөнөөлт</p>	Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан, тариалсан газар гарал үүслийн гэрчилгээтэй байна.



		<p>шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, механик элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна.</p> <p>5.Хадгалсан байцааг нийлүүлэхдээ гадна талын муудсан навчийг авч цэвэрлэсэн байх ба хөлдөлт, хайрагдалтгүй, жин нь 3 кг-аас доошгүй байна.</p> <p>6.Байцааг MNS 3529:1983 стандартын шаардлага хангасан шуудайд хадгалж тээвэрлэх эсвэл нийлэг сав баглаа, боодол, техникийн шаардлага MNS 5547:2005 стандартын шаардлага хангасан уутанд савласан байх</p> <p>7.Байцааг норох, хөлдөхөөс хамгаалж бүрхүүлтэй зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>8.Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>	
3	Лууван	<p>1.Нийлүүлэх лууван нь орон нутагт тариалагдсан , MNS 0271:1982 стандартын шаардлага хангасан 1 сорт байна.</p> <p>2 Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлнэ.</p> <p>3.Лууван нь нягт, шүүслэг, хөндийрөөгүй, модорч хөгшрөөгүй, өлсч үрчийгээгүй, соёолоогүй, гэмтээгүй, ялзраагүй, механик элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй байна.</p> <p>4.Савлалт нь хуурай, цэвэр, даавуун шуудайд савласан байна.</p> <p>5.Лууванг норох, хөлдөхөөс хамгаалж бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>6.Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>	Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан. Гарал үүслийн гэрчилгээтэй байна.
4	Сонгино	<p>1.Нийлүүлэх сонгино нь орон нутагт тариалагдсан, MNS</p>	Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн

		<p>0260:1982стандартын шаардлага хангасан, монгол сонгино</p> <p>2.Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлнэ.</p> <p>4.Сонгино нь механик элдэв хольцгүй, хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, эрүүл, цэвэр, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна.</p> <p>5.Булцуу нь нягт, ургаж, соёолоогүй, ялзраагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай байна.</p> <p>6.Сонгиныг стандартын шаардлага хангасан шуудай, торон уутанд зэрэг, сортоор нь ялгаж савласан байна.</p> <p>7.Сонгиныг норох, хөлдөхөөс хамгаалсан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>8.Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ</p>	<p>хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан. Гарал үүслийн гэрчилгээтэй байна.</p>
5	Төмс	<p>1.Нийлүүлэх төмс нь орон нутагт тариалагдсан, MNS 258:2006 стандартын шаардлага хангасан байна.</p> <p>2.Шинэ буюу шинэлэг байдлаа хадгалсан, тариалсан газрын гарал үүсэл тодорхой байх</p> <p>3.Хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, бүтэн, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан гадаргуу нь цэвэр, шороогүй байх</p> <p>4.Хальс нь шалбарсан төмс 10 хувиас ихгүй, ногоорсон төмсгүй, пестицидийн үлдэгдэлгүй байх</p> <p>5.Гадны ямар нэг үнэртэй, химийн бодисоор бохирлогдсон байж болохгүй.</p> <p>6.Төмсний голчийн хэмжээ 35-55 мм, 55мм-ээс дээш байна.</p> <p>7.Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байна.</p>	<p>Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан байх</p>

		<p>8.Төмсийг норох, хөлдөхөөс хамгаалж бүтээлэгтэйгээр зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>9. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>	
6	<p>-Шар манжин</p> <p>-Хүрэн манжин</p>	<p>1.Нийлүүлэх манжин нь орон нутагт тариалагдсан , MNS 0268:1973 стандартын шаардлага хангасан /1 дүгээр зэргийн</p> <p>2.Ил болон хамгаалагдсан хөрсөнд ургуулсан манжинг нийлүүлнэ.</p> <p>3.Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлнэ.</p> <p>4.Хортон, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, үндэс үр нь шинэ бүтэн,эрүүл, хагаралтгүй, хөгшрөөгүй, наалдсан шороогүй, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна.</p> <p>5.Савлалт нь хуурай, цэвэр, шуудайлж савласан байх.</p> <p>6.Ногоог норох, хөлдөхөөс хамгаалж бүрхүүлтэй зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>7.Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ</p>	<p>Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан Гарал үүслийн гэрчилгээтэй байна.</p>
7	<p>-Амтат чинжүү</p> <p>-Өргөст хэмх</p> <p>-Улаан лооль</p> <p>-Брокли</p> <p>-хулуу</p> <p>-Бууцай</p> <p>-Юуцай</p> <p>-Цагаан гаа</p> <p>-Лемон</p> <p>-Яншуй</p>	<p>1.Ариун цэвэр эрүүл ахуйн шинжилгээнд оруулсан, гарал үүслийн бичигтэй байна</p> <p>2.Хортон, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, эрүүл, хагаралтгүй, хөгшрөөгүй, наалдсан шороогүй, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна.</p> <p>3.Савлалт нь хуурай, цэвэр, шуудайлж савласан байх.</p> <p>4.Ногоог норох, хөлдөхөөс хамгаалж бүрхүүлтэй зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>5. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ</p>	<p>Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан, гарал үүслийн гэрчилгээтэй байна.</p>

8	Сармис	<p>1.Нийлүүлэх сармис нь орон нутагт тариалагдсан MNS 0267:73 стандартын шаардлага хангасан 1 дүгээр зэргийнх байна.</p> <p>2.Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлнэ.</p> <p>3. Сармис нь механик хольцгүй, хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, хөлдөөгүй, соёолоогүй, сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан байна.</p> <p>4.Булцууны болц бүрэн гүйцсэн, цэвэр, хальс нь бүтэн, гэмтэж хагараагүй, хумсууд нь нягт, бүрхүүл хальстай шороогүй байх ба өөр өнгийн сармисны хольц байж болохгүй.</p> <p>5.Савлалт нь хуурай, цэвэр, даавуун, цаасан шуудай эсвэл торон уутанд савласан байна.</p> <p>6.Сармисыг норох, хөлдөхөөс хамгаалж бүрхүүлтэй зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>7.Бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>	Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан Гарал үүслийн гэрчилгээтэй байна.
9	<p>-Алим</p> <p>-Мандарин</p> <p>-Гадил</p>	Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн ОХУ-д тариалсан.	Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан

## V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

### Маягт 1.Тендер илгээх маягт

[2024,02,16]

**[Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэг]-д**

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[ДААДСЦ/27/20240202010]** тендер шалгаруулалтад **[62,875,000 Жаран хоёр сая найман зуун далан таван мянган ]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “**тендер**” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” төсөв өртгийн нэг хувь]**.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

### **Г. Цэцэглэн**

**Үнэлгээний хорооны нарийн бичиг**

**байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг: Дархан-Уул аймгийн Дархан сумын 8-р баг**

---

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

**Маягт 2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

**Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

**Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга**

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ.

**Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь**

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

**Маягт 7. Хүний нөөцийн мэдээлэл**

<b>Албан тушаал</b>	<b>Ажилтны нэр</b>	<b>Боловсрол, мэргэжлийн ур чадвар</b>	<b>Нийт ажлын туршлага, жилээр</b>	<b>Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр</b>

## Маягт 8. Санал болгож буй ажилтны жишиг намтар (сv)

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Овог, нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

Ур чадварын:

*[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]*

\_\_\_\_\_

Боловсрол:

*[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]*

Ажилласан туршлага:

*[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]*

\_\_\_\_\_

Хэлний мэдлэг:

*[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]*

\_\_\_\_\_

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_



**Маягт 9. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл**

<b>Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт</b>	<b>Хүчин чадал</b>	<b>Тоо ширхэг</b>	<b><i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i></b>

**Маягт 10. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	<b>Нууцалсан баримт бичиг, мэдээлэл</b>	<b>Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл</b>
1.		
2.		
3.		
4.		
5.		

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ үзүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;

1. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
2. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
3. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
4. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
5. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
6. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Үйлчилгээ” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
  - 1.1.8. “Ажлын байр” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
  - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
  - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
  - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
  - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

### **ХОЁР. ЗАХИАЛАГЧ**

- |                        |         |      |   |
|------------------------|---------|------|---|
| Захиалагчийн үүрэг     | нийтлэг | 2.1. | Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.  |
|                        |         | 2.2. | Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.   |
|                        |         | 2.3. | Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна. |
| Захиалагчийн төлөөлөгч |         | 2.4. | Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.  |
|                        |         | 2.5. | Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.  |
|                        |         | 2.6. | Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.                |
| Талбайд зөвшөөрөл      | нэвтрэх | 2.7. | Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.                  |
|                        |         | 2.8. | Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.            |

### **ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ**

- |                     |         |      |  |
|---------------------|---------|------|--|
| Гүйцэтгэгчийн үүрэг | нийтлэг | 3.1. | Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.   |
|                     |         | 3.2. | Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.             |
|                     |         | 3.3. | Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна. |

- 3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
- 3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл 3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Аюулгүй байдал 3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

#### **ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН**

- Ажил эхлэх 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.

- |                    |   |
|--------------------|---|
| Хугацаа сунгах     | <p>4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.</p> <p>4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <p>4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;</p> <p>4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;</p> <p>4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;</p> <p>4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.</p>  |
| Ажлын явцын тайлан | <p>4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.</p> <p>4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.</p> <p>4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.</p> <p>4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.</p> |

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- |                   |  |
|-------------------|--|
| Гэрээний үнэ      | <p>5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягад заана.</p> <p>5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> |
| Урьдчилгаа төлбөр | <p>5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p>        |

- |                  |   |
|------------------|---|
| Төлбөрийн нөхцөл | <p>5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.</p> <p>5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.</p> <p>5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p> |
|------------------|---|

### **ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА**

- |                       |           |  |
|-----------------------|-----------|--|
| Урьдчилгаа баталгаа   | төлбөрийн | <p>6.1. ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.</p>   |
| Гүйцэтгэлийн баталгаа |           | <p>6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.</p> <p>6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:</p> <p>6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;</p> <p>6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</p> <p>6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.</p> <p>6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.</p> <p>6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.</p> <p>6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.</p> |
| Чанарын баталгаа      |           | <p>6.7. Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.</p> <p>6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>6.9. ГЕН-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p>  |

- 6.10. Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

#### **ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ**

- |                         |           |  |
|-------------------------|-----------|--|
| Бусдад хохирлыг арилгах | учруулсан | <p>7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.</p>  |
| Захиалагчийн эрсдэл     | хүлээх    | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;</p> <p>7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;</p> <p>7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.</p>   |
| Даатгал                 |           | <p>7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.</p> <p>7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.</p> <p>7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.</p> <p>7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.</p> <p>7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.</p> |



## НАЙМ. ДОГОЛДОЛ

- |                        |           |   |
|------------------------|-----------|---|
| Доголдлыг арилгах      | илрүүлэх, | 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.   |
|                        |           | 8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.                        |
|                        |           | 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. |
|                        |           | 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.  |
|                        |           | 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.   |
|                        |           | 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.  |
|                        |           | 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.  |
|                        |           | 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.  |
| Далд доголдол          |           | 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.  |
| Зураг төслийн доголдол |           | 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.  |
|                        |           | 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.  |

## ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- |                         |   |
|-------------------------|---|
| Захиалагч гэрээг цуцлах | 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:  |
|                         | 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй;  |
|                         | 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;  |
|                         | 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;                                   |
|                         | 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон; |
|                         | 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;   |

- 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
- 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
- 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;

- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

#### **АРАВ. БУСАД ЗААЛТ**

Мэдэгдэл

- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
  - 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
  - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

Төлөөлөгч өөрчлөгдөх

- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.

- Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл
- 10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн давагдашгүй шинжтэй байдал буюу хүчний онцгой нөхцөл
- 10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-д заасан хүсэлтийг гаргаж болно.
- Оюуны өмчийн эрх зөрчих
- 10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги
- 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл

Маргаан шийдвэрлэх

хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.

10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>
ГЕН 4.2.	Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>
ГЕН 4.9.	Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>
ГЕН 5.2.	<p>Үнийн тохируулга: <b>[“Хийнэ”, “Хийхгүй” аль нэгийг сонгох]</b></p> <p><b>Хэрвээ тохируулга хийх бол:</b></p> <p><b>[Зөвхөн үндсэн материал, түүхий эд, ажиллах хүчний зардлын хэлбэлзлийг тусгах зорилгоор үнийн тохируулга хийнэ. Ингэхдээ төлбөрийн мэдэгдлийн нийт дүнгээс урьдчилгаа төлбөрийг хассан дүнгийн төлбөр хийх валют тус бүрийн үнийн дүнг холбогдох үнийн тохируулгын үзүүлэлт (<math>P_c</math>)-ийг ашиглан тохируулна.</b></p> $P_c = A_c + B_c \cdot I_{m_c} / I_{o_c}$ <p><b>Энд:</b></p> <p><math>P_c</math> – гэрээний үнийн “с” валютаар төлөгдөх хэсэгт хийх үнийн тохируулгын үзүүлэлт;</p> <p><math>A_c</math> ба <math>B_c</math> – гэрээний үнийн “с” валютаар төлөгдөх хэсгийн тохируулга хийгдэхгүй болон хийгдэх хувийн жинг үзүүлсэн, гэрээний тусгай нөхцөлд заасан итгэлцүүр;<sup>2</sup></p> <p><math>I_{m_c}</math> – нэхэмжилж буй сарын эцсийн хоногт зонхилж буй “с” валютын индекс;</p> <p><math>I_{o_c}</math> – тендерийг нээх өдрийн зонхилж буй “с” валютын индекс</p> <p><b>Хэрэв индексийн дүн нь түүнийг тооцоонд ашигласнаас хойш өөрчлөгдсөн бол тооцоог залруулж, дараагийн төлбөрийн мэдэгдэлд энэ дагуу тохируулга хийнэ. Индексийн дүнг тооцохдоо үнийн хэлбэлзлийн улмаас гарсан зардлын бүх өөрчлөлтийг энд харгалзсан гэж үзнэ.]</b></p>
ГЕН 5.4.	<p>Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>[“Тийм”, “Үгүй” аль нэгийг сонгох]</b></p> <p><b>Хэрвээ урьдчилгаа төлбөр олгох бол:</b></p> <p>Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <b>[мөнгөн дүн бич]</b></p>
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: <b>[ажлын хоног бичих]</b>
ГЕН 5.6.	<p>Төлбөр төлөх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b></p> <p>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: <b>[он, сар, өдөр]</b></p>
ГЕН 6.1.	<p>Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <b>[мөнгөн дүн бич]</b></p> <p>Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b></p>

<sup>2</sup>  $A_c$  ба  $B_c$  – гэсэн хоёр итгэлцүүрийн нийлбэр нь валют бүрийн томъёонд 1 (нэг) байна. Энэ хоёр итгэлцүүр нь ихэвчлэн ихэнх валютын хувьд ижил байдаг. Төлбөрийн тохируулга хийхгүй хэсэгт зориулсан  $A$  итгэлцүүр нь тогтмол үнийн болон бусад тохируулга үл хийгдэх элементүүдийг тусгасан ойролцоо үзүүлэлт (ихэвчлэн 0,15) юм. Валют бүрийн тохируулгын дүнг гэрээний үнэд нэмнэ.

ГЕН 6.7.	<p><b>Чанарын баталгаа:</b></p> <p>Чанарын баталгаа шаардах эсэх: <b><i>["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих.]</i></b></p> <p><i>Чанарын баталгаа шаардах бол,</i></p> <p>Чанарын баталгааны хэмжээ: <b><i>[Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийн хооронд сонго.]</i></b></p>
ГЕН 6.13.	<p>Баталгаат хугацаа: <b><i>[Тендер шалгаруулалтын баримт бичигт үндэслэн баталгаат хугацааг тогтоож бичих]</i></b></p>
ГЕН 7.5.	<p>Даатгал:</p> <p><b><i>[Ажлын онцлогийг харгалзан гарч болох эрсдэлийг тодорхойлон Гүйцэтгэгчийн даатгуулах даатгалуудыг нэрлэн бичих]</i></b></p>
ГЕН 10.21.	<p><b>Захиалагчийн төлөх алдангийн хувь:</b></p> <p>Алдангийн хувь: <b><i>[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]</i></b></p>
ГЕН 10.22.	<p><b>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:</b></p> <p>Алдангийн хувь: <b><i>[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]</i></b></p>

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

**[Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх]** гэрээ.

Дугаар № **[ДААДСЦ27/20240202010]**

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
  - 3.7. Техникийн тодорхойлолт;
  - 3.8. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:



Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **[2024,02,16]**  
Тендер шалгаруулалтын төрөл: Үйлчилгээ  
Тендер шалгаруулалтын нэр: **[Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх]**  
Тендер шалгаруулалтын дугаар: **[ДААДСЦ27/20240202010]**  
Нийт төсөвт өртөг: **[62,875,000]**  
Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

1. **[Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэг]** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **[“Тийм”]**

**Багц № 1: Үхрийн мах,махан бүтээгдэхүүн-132480**

**Багц № 2: Гурилан бүтээгдэхүүн-53900**

**Багц №3: Төмс хүнсний ногоо-38885**

**Багц №4: Гурил- 12000**

**Багц №5: Хуурай хүнс, жимс жимсгэнэ, хүнсний бүтээгдэхүүн-45612**

**Багц №6: Сүү,сүүн бүтээгдэхүүн- 31498**

**тендерийн баталгаа ирүүлнэ.**

3. Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **[зургаа]**

4. Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: **[34,2,2]**

5. Үнийн санал дуудах ажиллагааг **[2024,02,16-ны 11:00]**–т эхлүүлж, **[хоёроос доошгүй цаг байхаар заана]** хугацаанд зохион байгуулна.

6. Тендерийг **[2024,03,06-ны 13:00]**–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **[2024,03,06]-ны өдрийн, [13:30]-т** нээнэ.

7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **[“Зөвшөөрөхгүй”]**

8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **[“Эрхгүй”]**

9. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

**[Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэг  
Утас:70376227, 99376150 Үнэлгээний хорооны нарийн бичиг  
10 тоот өрөө ]**

**Бараа нийлүүлэлтийн хуваарь**

*[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]*

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжигнэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
<b>Багц-1 дотоодын бүтээгдэхүүн / Үхрийн мах, махан бүтээгдэхүүн/</b>						
1	Үхрийн мах	2060	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
2	Дотор мах	286	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
3	Тахианы мах	315	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
<b>Багц-2 дотоодын бүтээгдэхүүн / Гурилан бүтээгдэхүүн/</b>						
1	Төрөл бүрийн гурилан боов	1960	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
<b>Багц-3 дотоодын бүтээгдэхүүн / Төмс хүнсний ногоо /</b>						

1	Төмс	1350	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
2	Лууван	540	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
3	Сонгино	180	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
4	Шар манжин	450	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
5	Хүрэн манжин	270	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
6	Байцаа	630	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
7	Сармис	46	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал

**Багц-4 дотоодын бүтээгдэхүүн / Гурил /**

1	Гурил	1200	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
---	-------	------	----	---	---

**Багц-5 дотоодын бүтээгдэхүүн / Хуурай хүнс, жимс жимсгэнэ,бусад хүнсний бүтээгдэхүүн/**

1	Цагаан будаа	180	кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
2	Шар будаа	45	Ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
3	Гурвалжин будаа	72	Ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
4	Хүүхдийн будаа	72	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал

5	Хөц будаа	37	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
6	Элсэн чихэр	135	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
7	Ургамлын тос Олиеина	108	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
8	Овьёос 0.4 гр	72	ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
9	Вандуй 0.9 гр	54	ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
10	Исгэгч 0.20	18	Ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
11	Давс	90	кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
12	Вариань чанамал	72	ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
13	Брокли	45	кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
14	Аньс	54	кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
15	Нэрс	54	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
16	Чацаргана	54	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	
17	Шөлний далайн байцаа 0,1гр	45	ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал	

18	Лапша гоймон	54	кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
19	Хар чавга	44	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
20	Үзэм	45	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
21	Хэлбэртэй гоймон	44	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
22	Алим	64	кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
23	Масло	54	кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
24	Хүнсний сод 0,2гр	10	ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
25	Пакеттай цай	10	ш	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал

Багц-6 дотоодын бүтэгдэхүүн / Сүү сүүн бүтээгдэхүүн/

1	Сүү	900	Л	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
2	Аарц	89,9	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
3	Ааруул	45	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
4	Зөөхий 0,3 гр Өлзий	45	Кг	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал
5	Тараг	90	Л	Дархан сумын 27-р цэцэрлэгийн хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 2025 оны нийлүүлэгч шалгартал



